



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн 9 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022 /43/ НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Орхон аймаг

2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах

Утас:70359826

Цахим хаяг:orkhon@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ

Утас:70355805

Цахим хаяг:erdeneb@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Оргилмөрөн

Утас:70350757

Цахим хаяг:orgilmurung@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт.....	14
4.1 Залруулсан алдаа	14
4.2 Албан шаардлага	14
4.3 Зөвлөмж	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
АО	Ажил олгогч
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

1099.02.95 № 65

танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН 9 ДҮГЭЭР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Х.САНСАРТУЯА ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 9 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

9 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.



Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>27,420,419.44</u>	<u>28,198,853.44</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,942,093.44	1,142,093.44
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,942,093.44	1,142,093.44
3121	Төгрөг	1,942,093.44	1,142,093.44
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	1,942,093.44	1,142,093.44
33	АВЛАГА	0.00	1,464,974.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	1,464,974.00
35	БАРАА МАТЕРИАЛ	25,478,326.00	25,591,786.00
351	Түүхий эд материал	21,360,880.00	21,827,180.00
35110	Тусгай зориулалттай материал	21,210,280.00	21,656,780.00
35130	Эм боох материал	150,600.00	170,400.00
354	Хангамжийн материал	4,117,446.00	3,764,606.00
35410	Бичиг хэргийн материал	2,311,496.00	2,254,296.00
35420	Аж ахуйн материал	1,384,900.00	415,600.00
35450	Барилгын засварын материал	235,900.00	445,000.00
35460	Хүнсний материал	185,150.00	649,710.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,318,018,743.85</u>	<u>1,286,160,499.03</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,318,018,743.85	1,286,160,499.03
392	Биет хөрөнгө	1,117,458,743.77	1,085,700,498.91
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,127,068,206.00	1,127,068,206.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-50,328,762.96	-75,493,144.44
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	37,068,139.04	39,933,639.04
39206	Хуримтлагдсан элэгдэл	-25,104,247.66	-28,558,474.49
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	70,275,539.00	68,608,039.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-52,633,071.70	-55,129,095.73
39209	Зам, гүүрийн байгууламж	14,796,167.09	14,796,167.09
39210	Хуримтлагдсан элэгдэл	-3,683,225.04	-5,524,837.56
393	Биет бус хөрөнгө	200,560,000.08	200,460,000.12
39301	Програм хангамж	400,000.00	400,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-199,999.92	-299,999.88
39303	Бусад биет бус хөрөнгө	200,360,000.00	200,360,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,345,439,163.29</u>	<u>1,314,359,352.47</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,345,439,163.29</u>	<u>1,314,359,352.47</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,345,439,163.29	1,314,359,352.47
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	484,373,149.00	484,373,149.00
51101	Өмч: - төрийн	284,013,149.00	284,013,149.00
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	200,360,000.00	200,360,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	-160,712,095.29	-191,791,906.11
51210	Өмнөх үеийн үр дүн	-133,093,671.81	-160,712,095.29
51220	Тайлант үеийн үр дүн	-27,618,423.48	-31,079,810.82
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,021,778,109.58	1,021,778,109.58
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,345,439,163.29</u>	<u>1,314,359,352.47</u>



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	443,326,845.00	420,999,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	19,217,045.00	6,056,100.00
120	Нийтлэг татварын бус орлого	19,217,045.00	6,056,100.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	19,217,045.00	0.00
1E+06	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	19,217,045.00	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		2,865,500.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		3,190,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	424,109,800.00	414,943,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	385,687,500.00	376,166,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	385,687,500.00	376,166,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	355,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	250,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	105,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	38,422,300.00	38,422,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	38,422,300.00	38,422,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	470,544,368.48	452,079,410.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	470,544,368.48	452,079,410.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	455,007,834.48	437,774,117.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	314,542,294.00	311,367,675.00
210101	Үндсэн цалин	189,184,297.00	181,579,598.00
210102	Нэмэгдэл	99,519,866.00	106,370,500.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	874,800.00	752,000.00
210104	Урамшуулал	24,963,331.00	22,665,577.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,603,885.00	40,396,501.00
210201	Тэтгэврийн даатгал	27,071,485.00	27,991,877.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,133,100.00	3,101,156.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,506,500.00	2,480,925.00
210204	Ажилгүйдлийн даатгал	626,600.00	620,231.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,266,200.00	6,202,312.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,366,227.00	23,863,527.00
210301	Гэрэл, цахилгаан	2,115,833.00	1,889,261.00
210302	Түлш, халаалт	18,114,472.00	17,044,226.00
210303	Цэвэр, бохир ус	5,135,922.00	4,930,040.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,338,460.00	3,826,000.00
210401	Бичиг хэрэг	35,200.00	105,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	156,400.00	29,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,696,810.00	570,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,005,950.00	2,449,900.00
210408	Бараа материал акталсны зардал	1,444,100.00	671,200.00
2105	Нормативт зардал	20,365,700.00	19,152,470.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	99,200.00
210502	Хоол, хүнс	20,046,700.00	18,619,070.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	319,000.00	434,200.00



2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,142,000.00	877,100.00
210604	Урсгал засвар	1,142,000.00	877,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	101,800.00	28,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	101,800.00	28,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	43,547,468.48	38,262,844.82
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,871,200.00	3,539,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	38,676,268.48	34,723,744.82
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,536,534.00	14,305,293.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,833,178.00	800,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,833,178.00	800,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	13,416,673.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		13,416,673.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,703,356.00	88,620.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,703,356.00	88,620.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-27,217,523.48	-31,079,810.82
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	400,900.00	0.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	400,900.00	0.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-400,900.00	0.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-27,618,423.48	-31,079,810.82

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	484,373,149.00	1,021,778,109.58	-160,712,095.29	1,345,439,163.29
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	484,373,149.00	1,021,778,109.58	-160,712,095.29	1,345,439,163.29
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	484,373,149.00	1,021,778,109.58	-160,712,095.29	1,345,439,163.29
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-31,079,810.82	-31,079,810.82
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	484,373,149.00	1,021,778,109.58	-191,791,906.11	1,314,359,352.47

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	429,008,855.00	416,165,427.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	429,008,855.00	416,165,427.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	385,687,500.00	376,166,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	385,687,500.00	376,166,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	355,000.00



131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	250,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	105,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	38,422,300.00	38,422,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	38,422,300.00	38,422,300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	4,899,055.00	1,221,927.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	4,899,055.00	1,221,927.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	429,278,855.00	416,965,427.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	429,278,855.00	416,965,427.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	408,843,266.00	401,438,207.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	314,542,294.00	312,832,649.00
210101	Үндсэн цалин	189,184,297.00	183,044,572.00
210102	Нэмэгдэл	99,519,866.00	106,370,500.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	874,800.00	752,000.00
210104	Урамшуулал	24,963,331.00	22,665,577.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,603,885.00	40,396,501.00
210201	Тэтгэврийн даатгал	27,071,485.00	27,991,877.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,133,100.00	3,101,156.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,506,500.00	2,480,925.00
210204	Ажилгүйдлийн даатгал	626,600.00	620,231.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,266,200.00	6,202,312.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,366,227.00	23,863,527.00
210301	Гэрэл, цахилгаан	2,115,833.00	1,889,261.00
210302	Түлш, халаалт	18,114,472.00	17,044,226.00
210303	Цэвэр, бохир ус	5,135,922.00	4,930,040.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,512,410.00	2,224,900.00
210401	Бичиг хэрэг	35,200.00	240,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	156,400.00	29,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,147,210.00	570,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	173,600.00	1,385,000.00
2105	Нормативт зардал	20,874,350.00	19,563,230.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	150,600.00	45,400.00
210502	Хоол, хүнс	20,190,750.00	19,083,630.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	533,000.00	434,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,142,000.00	1,142,100.00
210604	Урсгал засвар	1,142,000.00	1,142,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	101,800.00	28,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	101,800.00	28,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,700,300.00	1,387,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,700,300.00	1,387,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,435,589.00	15,527,220.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,732,233.00	2,021,927.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	4,899,055.00	1,221,927.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,833,178.00	800,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	13,416,673.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		13,416,673.00



2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,703,356.00	88,620.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,703,356.00	88,620.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>-270,000.00</u>	<u>-800,000.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-270,000.00	-800,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,212,093.44	1,942,093.44
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,942,093.44	1,142,093.44

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Дүн	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	414,588,500.00	401,083,207.00	13,505,293.00	96.7%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	414,588,500.00	401,083,207.00	13,505,293.00	96.7%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	414,588,500.00	401,083,207.00	13,505,293.00	96.7%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	312,832,700.00	312,832,649.00	51.00	100.0%
210101	Үндсэн цалин	161,857,800.00	183,044,572.00	-21,186,772.00	113.1%
210102	Нэмэгдэл	123,256,300.00	106,370,500.00	16,885,800.00	86.3%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,535,300.00	752,000.00	1,783,300.00	29.7%
210104	Урамшуулал	25,183,300.00	22,665,577.00	2,517,723.00	90.0%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,396,600.00	40,396,501.00	99.00	100.0%
210201	Тэтгэврийн даатгал	27,831,000.00	27,991,877.00	-160,877.00	100.6%
210202	Тэтгэмжийн даатгал	3,141,400.00	3,101,156.00	40,244.00	98.7%
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,513,100.00	2,480,925.00	32,175.00	98.7%
210204	Ажилгүйдлийн даатгал	628,300.00	620,231.00	8,069.00	98.7%
210205	Эрүүл мэндийн даатгал	6,282,800.00	6,202,312.00	80,488.00	98.7%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,280,200.00	23,863,527.00	13,416,673.00	64.0%
210301	Гэрэл, цахилгаан	9,101,000.00	1,889,261.00	7,211,739.00	20.8%
210302	Түлш, халаалт	16,236,700.00	17,044,226.00	-807,526.00	105.0%
210303	Цэвэр, бохир ус	11,942,500.00	4,930,040.00	7,012,460.00	41.3%
2104	Хангамж, бараа материалын зардал	1,869,900.00	1,869,900.00	0.00	100.0%
210401	Бичиг хэрэг	78,900.00	135,000.00	-56,100.00	171.1%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	162,500.00	29,900.00	132,600.00	18.4%
210404	Ном, хэвлэл	49,400.00	0.00	49,400.00	0.0%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	560,300.00	570,000.00	-9,700.00	101.7%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,018,800.00	1,135,000.00	-116,200.00	111.4%
2105	Нормативт зардал	19,651,700.00	19,563,230.00	88,470.00	99.5%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	45,400.00	45,400.00	0.00	100.0%
210502	Хоол, хүнс	19,170,800.00	19,083,630.00	87,170.00	99.5%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	435,500.00	434,200.00	1,300.00	99.7%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,142,100.00	1,142,100.00	0.00	100.0%
210604	Урсгал засвар	1,142,100.00	1,142,100.00	0.00	100.0%



2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,000.00	28,000.00	0.00	100.0%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	28,000.00	28,000.00	0.00	100.0%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,387,300.00	1,387,300.00	0.00	100.0%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,387,300.00	1,387,300.00	0.00	100.0%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	414,588,500.00	401,083,207.00	13,505,293.00	96.7%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	376,166,200.00	376,077,580.00	88,620.00	100.0%
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	376,166,200.00	376,077,580.00	88,620.00	100.0%
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	38,422,300.00	25,005,627.00	13,416,673.00	65.1%
132001	Орон нутгийн төсвөөс	38,422,300.00	25,005,627.00	13,416,673.00	65.1%
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	1,942,093.44		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	1,142,093.44		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00	100.0%
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.0%
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	27.50	27.50	0.00	100.0%
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.0%
620002	Гүйцэтгэх ажилтан	17.00	17.00	0.00	100.0%
620003	Үйлчлэх ажилтан	9.50	9.50	0.00	100.0%
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	27.50	27.50	0.00	100.0%
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	15.00	15.00	0.00	100.0%
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	1.00	1.00	0.00	100.0%
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	11.50	11.50	0.00	100.0%

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл (төгрөгөөр)
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	355,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	355,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	355,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	355,000.00
210401	Бичиг хэрэг	0.00	105,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	250,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	355,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	355,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	250,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	105,000.00



3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхон аймгийн 9 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд бүртгэл санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Оргилмөрөн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон аймгийн 9 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Орхон аймгийн 9-р цэцэрлэгийн үйл ажиллагааг Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулиар “Хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны хүүхдийг асрах, хамгаалах, хөгжүүлэх цогц үйл ажиллагаа бүхий сургалтын байгууллага” гэж тодорхойлсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын хууль тогтоомж, Нийгмийн даатгалын хууль тогтоомж, ТБОНӨХБАҮХАТ хууль зэрэгт өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ



илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон аймгийн 9 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийн нийт зардал ба цэвэр зээлийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл **дунд** гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн 414,588.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 4,145.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2,902.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Орхон аймгийн 9 дүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 31,079.8 мянган төгрөгөөр буюу 2.3 хувиар буурсан байна. Нийт хөрөнгийн бууралт нь тайлант оны үндсэн хөрөнгийн бууралттай холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,942.1	1,142.1	-800.0
Авлага	0.00	1,464.9	1,464.9
Урьдчилгаа			
Бараа материал	25,478.3	25,591.8	113.5
Үндсэн хөрөнгө	1,318,018.7	1,286,160.5	-31,858.2
Нийт хөрөнгө	1,345,439.2	1,314,359.4	-31,079.8
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,345,439.2	1,314,359.4	-31,079.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,345,439.2	1,314,359.4	-31,079.8

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,142.1 мянган төгрөг болж 800.0 мянган төгрөгөөр буурсан нь ахмадын сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс тайлант онд зарцуулснаас шалтгаалжээ.

Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны хувь хүний орлогын албан татварын суутгалтай холбоотойгоор Татварын хэлтсээс 1,464.9 мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 25,591.8 мянган төгрөг болж 113.5 мянган төгрөгөөр өссөн байна. Тайлант онд эхлэгчийн тушаалаар 671.2 мянган төгрөгийн ашиглалтын шаардлага хангахгүй болсон материал акталсан, эцэг эхийн хандив тусламжаар 3,190.6 мянган төгрөгийн материал үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Аудитын код: ОРА-2022 /43/ НА-СТА-ТШЗ



Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,286,160.5 мянган төгрөг болж 31,858.2 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант онд 2,865.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж үнэ төлбөргүй хүлээн авсан бөгөөд элэгдлийн зардал 34,723.7 мянган төгрөг тул үндсэн хөрөнгийн данс буурсан байна. Мөн аймгийн Засаг даргын захирамжаар ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 1,667.5 мянган төгрөгийн дансны үнэтэй тавилга эд хогшил акталсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,314,359.4 мянган төгрөг болж 31,079.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Орхон аймгийн 9 дүгээр цэцэрлэгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 22,327.2 мянган төгрөгөөр буюу 5.0 хувиар буурсан байна. Өмнөх оноос орлого буурсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого болон тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтийн орлогоос шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 18,464.9 мянган төгрөгөөр буюу 3.9 хувиар буурсан байна. Энэ нь цалингийн зардал болон тогтмол зардал, хангамж бараа материалын зардал, бараа үйлчилгээний бусад зардалтай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн 465,300.5 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээр болон орон нутгийн төсвөөс, 39,672.3 мянган төгрөгийг өөрийн орлогоор бүрдүүлж, нийт зарлагыг 504,972.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 90,384.3 мянган төгрөгөөр бууруулж, тус байгууллагын 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн 376,166.2 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 38,422.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, нийт зарлагыг 414,588.5 мянган төгрөгөөр тооцон баталж төсөвлөсөн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71801 /Сургуулийн өмнөх боловсрол/ хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр тусгай зориулалтын шилжүүлгээр 376,166.2 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 38,422.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 401,083.2 мянган төгрөгийг зарцуулж 13,505.3 мянган төгрөгийг улс, орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 401,083.2 мянган төгрөг буюу 96.7 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 13,416.7 мянган төгрөгөөр дутуу /хэмнэсэн/ зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн



бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансны 355.0 мянган төгрөгийн гүйлгээ тайлагнасан байна. Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө ангиллаар 250.0 мянган төгрөг, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого ангиллаар 105.0 мянган төгрөг авч зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудит хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Орхон аймгийн 9 дүгээр цэцэрлэгийн төвийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 талбарын мэдээллээс хугацаандаа оруулсан 150 талбарын мэдээлэл, 1 талбарын мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 2,250.0 мянган төгрөгийн зөрчилд өгсөн 1 албан шаардлага, мөн аудитаар хүргүүлсэн 2 зөвлөмжийн биелэлт хангагдсан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Орхон аймгийн 9 дүгээр цэцэрлэгийн санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгөн шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй ба дараагийн аудитаар бараа материал, үндсэн хөрөнгийн дансыг авч үзэж болох юм.



4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 221,759.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 219,832.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 434.2 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 1,492.6 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Санхүүгийн тайланд биет бус хөрөнгөөр бүртгэлтэй газрын үнэлгээний 200,360.0 мянган төгрөгийг санхүүгийн байдлын тайлангийн эзний өмчийн хэсэгт засгийн газрын сангаар тайлагнасан байна. Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн дансанд тусгах аргачлал"-ын 5.5-д газрыг засгийн газрын сангийн эзэмшигчийн өмчийн бусад хэсэгт тайлагнахаар тусгагдсан болно.
- Тайлант онд үнэ төлбөргүй хүлээн авсан 2,865.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 3,190.6 мянган төгрөгийн бараа материал буюу нийт 6,056.1 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлогын дансны ангиллыг алдаатай илэрхийлсэн байна. Мөн оны эцэст орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн 13,416.7 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийн дансны ангиллыг алдаатай илэрхийлсэн байна.

4.2 Албан шаардлага

1. Тайлант оны 12-р сард 434.2 мянган төгрөгийн ажлын дүрэмт хувцас худалдан авч Засгийн газрын 2021 оны 43-р тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.4 дахь заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны хувь хүний орлогын албан татварын суутгалтай холбоотойгоор Татварын хэлтсээс 1,464.9 мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Үүссэн авлагыг барагдуулж, цаашид Төсвийн тухай хуулийн 6.4.8-д заасныг хэрэгжүүлж авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах.

2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тайлант оны жилийн дүнгээр цалингийн зардлаас АО-с төлөх НДШ-ийн зардалд 27.7 мянган төгрөг гүйлгэн зарцуулсан байна.



Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэсэн заалтуудтай нийцэхгүй, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 3.1.6-д “Төсвийн тухай хуулийн 42.4-т заасны дагуу дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг албан бичгээр авсан байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

3. Дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрөлгүйгээр цалин, АО-с төлөх НДШ-ийн зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 05 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Орхон аймгийн 9-р цэцэрлэг	1	27.7							1	27.7
2	Орхон аймгийн 9-р цэцэрлэг	1	1,464.9							1	1464.9
3	Орхон аймгийн 9-р цэцэрлэг	1	434.2					1	434.2		
4	Орхон аймгийн 9-р цэцэрлэг	1	200,360.0	1	200,360.0						
5	Орхон аймгийн 9-р цэцэрлэг	1	19,472.8	1	19,472.8						
Дүн		5	221,759.6	2	219,832.8	0	0.0	1	434.2	2	1,492.6